

2017 ОНЫ 07 ДУГААР САРЫН 17-НЫ ӨДРИЙН  
НИЙСЛЭЛИЙН УДИРДАХ АЖИЛТНУУДЫН ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨН ДЭЭР  
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН  
ЗАХИРАГЧИЙН ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАРЫН БИЕЛЭЛТ

№	Товч агуулга	Хэрэгжилт
1	Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал болон Тэргүүлэгчдийн хурлаар Бодлогын бичиг баримтыг боловсруулж батлуулахаар төлөвлөсөн ажлуудаа шуурхайлах. /Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Захирагчийн ажлын алба, Хэрэгжүүлэгч агентлаг, Нийслэлийн өмчит болон төсөт байгуулллагууд/	НИТХ-ын 2014 оны 221, 222 дугаар тогтоолоор батлагдсан Нийслэлийн сайн малчин, Нийслэлийн тэргүүний фермер шалгаруулах журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай -Оны шилдэг хүнс үйлдвэрлэгч хүнсний бүтээгдэхүүн шалгаруулах журам -Шимийн архины үйлдвэрлэлд хяналт тавих журмуудыг холбогдох хууль журмуудад нийцүүлэн боловсруулж байна.
2	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын удирдлагууд болон ажилтнууд баталсан графикийн дагуу 2017 оны ээлжийн амралтаа эдлүүлэх, шаардлагатай тохиолдолд холбогдох гар утсаа нээлттэй байлгах, мөн төрийн ажил үйлчилгээ тасалдал, хүлээгдэл, чирэгдэлгүйгээр үргэлжлэх нөхцлийг бүрдүүлэх.	Албан хаагчдыг ээлжийн амралтын хувиарын дагуу амруулж, утсаа нээлттэй байлгах үүрэг даалгавар өгсөн.
3	НИТХ-ын Тэргүүлэгчдийн 2015 оны 85 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн нутаг дэвсгэрт мал аж ахуй эрхлэх журам”-ын хэрэгжилтийг сайтар хангах, нийслэлийн ногоон бүсэд гэрээр хоол, хүнсний худалдаа үйлчилгээ үзүүлж байгаад хяналт тавих. /Хүнс, хөдөө аж ахуйн газар, нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, Мал эмнэлэгийн газар, Дүүргүүд/	Мал аж ахуй эрхлэхийг хориглосон хороодын нутаг дэвсгэрт нэмж айл оруулахгүй байх талаар хороодын Засаг дарга нарт чиглэл хүргүүлж, холбогдох газруудтай хамтран ажиллалаа. Зуслангийн бүс болон хориглосон бүсэд байгаа малыг гаргах, нэмж мал оруулахгүй байх ажлыг зохион байгуулж Нийслэлийн Байгаль орчны газар, мэргэжлийн хяналтын газар, дүүргүүдийн тамгын газартай хамтарсан ажлын хэсгийг байгуулан 2017 оны 07 дугаар сарын 5,6-ны өдрүүдэд ажиллаж журмын хэрэгжилтийг ханган ажиллалаа